



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/257

Хэрлэн сум

Яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн А/58 дугаар тушаалаар батлагдсан “Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар”, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/136 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Адарга суманд 2025 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр гоц халдварт хонины цэцэг өвчин оношлогдсон тул тус суманд гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 27-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл шуурхай зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд дархлаажуулалтад шаардагдах вакцин, мэргэжлийн удирдлага, дархлаажуулалтын явц, технологи, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-т даалгасугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж шаардагдах бэлэн байдлыг хангуулан, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

